

## **ДОРНОГОВЬ АЙМГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗАР**

Огноо: **2020.02.10.**

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗАРТ БЕНЗИН,  
ШАТАХУУН, ШАТАХ ТОСЛОХ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОХ  
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

**Төслийн нэр:** Дорноговь аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт, бензин, шатахуун, шатах тослох материал нийлүүлэх.

**Төслийн дугаар:** ДГШШГГ/202001003

Сайншанд сум

## ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

*Дорноговь аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Дорноговь аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт түли, шатахуун, шатах тослох материал худалдан авах”-ыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.*

### Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар

Багцын дугаар

Багцын нэр

Багц: *Багц 1*

*Бензин шатахуун -14,000,000*

Багц: *Багц 2*

*Авто хийн газ 1,600,000*

Үнийн санал ирүүлэх , техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 төгрөгийг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)-ээр банкны меркантний системийг ашиглан төлнө.

Үнийн саналыг 2019 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 10:30 минутаас өмнө төрийн худалдан авах ажиллагааны систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ.

Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 Mb, нэг файлын хэмжээ 15 Mb байна..

Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь төрийн худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй.

Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй .

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2020 оны 02-р сарын 18-ны өдрийн **11:00 цагт** нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

(Дорноговь аймаг , Сайншанд сумын 6 -р баг Шинэ зуун-I гудамж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2-р давхарт №207 тоот

Утас: 89770259, 88937377

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |  |
|---|--|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч</b>          | <b>1.1.</b> Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.   |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>     | <b>2.1.</b> Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br><b>2.2.</b> Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.   |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                 | <b>3.1.</b> Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:<br><br>(а) Унийн санал;<br>(б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]   |
| <b>4. Тендерийн үнэ</b>                       | <b>4.1.</b> Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцгчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарыт үндэслэнэ.<br><b>4.2.</b> Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.<br><b>4.3.</b> Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарыт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.<br><b>4.4.</b> Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстай бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна. |
| <b>5. Унийн саналын хүчинтэй байх хугацаа</b> | <b>5.1.</b> Унийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш <b>45</b> хоногийн хугацаанд хүчинтэй байна.   |
| <b>6. Алдааг залруулах</b>                    | <b>6.1.</b> Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:<br><br>(а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэндэйг зөв гэж үзнэ;<br>(б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;  |

- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-НЫХОЛБОГДОХ ЗААЛТ	Шалгуур үзүүлэлт																	
ТОӨЗ 1.1 (а)	1. 2019 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан ирүүлэх бөгөөд e-balance цахим бүртгэлд бүртгэгдсэн байна.																	
	2. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жилд ”шатахуун, шатах тослох материал”-тай ижил төрлийн бараа нийлүүлж байсан гэрээний тухай мэдээлэл/-ийг дараах хүснэгтээр ирүүлнэ:																	
	<table border="1"> <thead> <tr> <th rowspan="2">№</th><th rowspan="2">гэрээний нэр</th><th rowspan="2">барааны нэр</th><th rowspan="2">гэрээний үнэ /мян төгр/</th><th colspan="3">Захиалагчийн мэдээлэл</th></tr> <tr> <th>нэр</th><th>хаяг</th><th>утасны дугаар</th></tr> </thead> <tbody> <tr> <td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr> </tbody> </table>	№	гэрээний нэр	барааны нэр	гэрээний үнэ /мян төгр/	Захиалагчийн мэдээлэл			нэр	хаяг	утасны дугаар							
№	гэрээний нэр					барааны нэр	гэрээний үнэ /мян төгр/	Захиалагчийн мэдээлэл										
		нэр	хаяг	утасны дугаар														
Дээрх мэдээллийн хамт өмнөх захиалагч байгууллагуудтай сүүлийн 2 жилд байгуулсан гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт, гэрээний хэрэгжсилтийн үр дүнгийн талаар өмнөх бүх захиалагчийн тодорхойлолтыг ирүүлнэ.																		
<p>3. Үнийн санал /байгууллагын албан бланк дээр/</p> <p>4. Тендерт оролцогч эрх бүхий болохoo илэрхийлсэн мэдэгдэл.</p> <p>5. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /нотариатаар баталгаажуулсан/</p> <p>6. Шатахуун импортлох тусгай зөвшөөрөл.</p> <p>7. Газрын тосны бүтээгдэхүүн, тос, тослох материал худалдах тусгай зөвшөөрөлтэй байх.</p> <p>8. Төлөөлөх этгээдийн итгэмжлэл.</p> <p>9. Нийлүүлэх шатахуун, шатах тослох материалын төрөл, чанар, гарал үүслийн гэрчилгээтэй байх.</p> <p>10. Барааны чанарын баталгааны гэрчилгээний хуулбар /нотариатаар баталгаажуулж ирүүлэх/</p> <p>11. Сүүлийн 2 жилд гүйцэтгэсэн борлуулалтын дундаж хэмжээ нь нийлүүлэхээр санал болгосон барааны нийт үнийн дүнгээс багагүй байх.</p> <p>12. Гэрээг гүйцэтгэхэд зайлшигүй шаардлагатай шатахуун түгээх станцын байршилын жагсаалт.</p> <p>13. Шатахуун түгээх салбарын байршил нь сумдад салбартай байх, шуурхай ажиллагааг хангахуйц байх.</p> <p>14. Татвар, харилцагч банк, нийгмийн даатгал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын тодорхойлолтууд ирүүлнэ. Тодорхойлолтууд нь гаргаснаас хойш 1 сарын дотор хүчинтэй байна. Татвар, хураамж, төлбөрөө төлсөн эсэхийг тендер нээсэн өдрөөр тооцно.</p>																		

	<p><i>Татвар, нийгмийн даатгал, банк, бусад байгууллагад хугацаа хэтэрсэн өр толбортэй, сүүлийн 3 жилд ял шийтгэлтэй, одоо өр толбортэй байсан нь холбогдох байгууллагуудаас ирүүлсэн тодорхойлолтоор нотлогдсон тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</i></p> <p>15. Тендерт оролцогч үнийн өсөлтөөс урьдчилан сэргийлэх тухай, үнийн өсөлтөөс хамаарах эрсдлийг өөрөө хариуцах тухай албан бичгээр мэдэгдэл ирүүлэх.</p> <p>16. Нийлүүлэх барааны стандартыг гаргаж байгууллагын эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулж ирүүлэх. /Монгол Улсад мөрдөж буй стандартад нийцсэн байх/  <i>Дээрхи нэмэлт материалындаас нэг буюу хэд хэдэн баримт бичиг нотлох баримт ирүүлээгүй, эсвэл шаардлага хангахааргүй, баталгаажилтгүй ба зөрчил бүхий хуурамч нотлох баримтууд ирүүлсэн, сүүлийн 1 жилд нийлүүлсэн бараа, ажил, үйлчилгээний чанар хангайлтгүй байсан нь өмнөх захиалагч байгууллагуудын тодорхойлолтоор болон хяналт шалгалтын байгууллагын дүгнэлтээр нотлогдсон зэрэг тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</i></p>
ТОӨЗ 1.3.	<p>Борлуулалтын хэмжээ: <i>Сүүлийн 2 жилийн борлуулалтын дундаж хэмжээ нь санал болгож буй үнийн дунгийн 100 хувиас багагүй хэмжээний борлуулалтын орлоготой байна.</i></p>
	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <i>Дорноговь аймаг, Сайншанд сум, 6 дугаар баг, Шинэ зууны 1 дугаар гудамж, 113 –р байр.</i></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <i>Tender.gov.mn хаягаар цахимаар ирүүлнэ.</i></p> <p>Огноо: <i>2020 оны 02 дугаар сарын 18-ны өдөр</i></p> <p>Цаг: <i>10 цаг 30 минут.</i></p>
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <i>Дорноговь аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар.</i></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <i>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2 дугаар давхарт, Сургалтын танхим 207 тоот-д</i></p> <p>Огноо: <i>2020 оны 02 дугаар сарын 18-ны өдөр</i></p> <p>Цаг: <i>11 цаг 00 минут.</i></p>
ТОӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</p> <p><b>Багц 1 - авто бинзен</b></p> <p><b>Багц 2 – ахуйн болон авто газ.</b></p>

**Дөрөв. БАРАА НИЙЛҮҮЛЭЛТЭНД ТАВИГДАХ ШААРДЛАГА,  
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

<b>№</b>	<b>Бараа болон холбогдох үйлчилгээний нэрс</b>	<b>Техникийн тодорхойлолт болон стандарт</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Техникийн үзүүлэлтэд тавигдах шаардлага</b>
1	A-80 бензин	MNS 217: 2006	Авто бензин	
2	Дизель түлш	MNS 217: 2006	Дизель түлш	
3	АИ-92	MNS 217: 2006	Авто бензин	
4	Масло			
5	Тосол			
6	Тормозны шингэн	Монгол Улсад хэрэглэгдэж байгаа стандартын дагуу	Тос тосолгооны материал	<ul style="list-style-type: none"> <li>• МУ-ын MNS 216: 2006, MNS 217: 2006 стандартад нийцсэн байх.</li> <li>• МУ-ын MNS4628:98, MNS4633-98 стандартын шаардлага хангасан ШТСтанцтай байх.</li> <li>• Эрүүл ахуйн шаардлага хангасан байх.</li> <li>• Тээвэрлэлт, Хадгалалт хамгаалалтын стандарт шаардлагыг хангсан байна.</li> <li>• Шинжилгээний лабораторийн итгэмжлэлтэй байх.</li> <li>• Чанарын баталгааг хангасан байх.</li> <li>• Нийлүүлэх бүтээгдэхүүний гарал үүслийг тендерийн бичиг баримтанд тусгаж өгсөн байх.</li> </ul> <p align="right">Бусад</p>
7	Хийн газ	Ууршилт багатай, стандартын шаардлага хангасан.	Авто газ	

- 1. Стандарт:** Монгол Улсад мөрдөж буй стандартад нийцсэн бараа байна. Тендерт оролцогч нь Стандартчлал хэмжил зүйн баталгаатай түгээгүүртэй байна.
- 2. Баглаа боодол:** Барааны чанар стандартыг нийлүүлэгч бүрэн хариуцна.
- 3. Бараа хүргэх газар :** Сумдад ажиллагаагаар явдаг тул Аймгийн ихэнх сумдад салбартай байх хүргэж нийлүүлэх боломжтой байх.

### **Шалгалт, туршилт**

Захиалагч шаардлагатай бол нийлүүлэгдэх барааны хувьд хийгдсэн байх ёстой үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилтын жагсаалтыг холбогдох мэдээллийн хамт ирүүлэхийг тендерт оролцогчоос шаардаж болно.

Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсвэл түүний итгэмжилсэн төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй.

## ТАВ. ЖИШИГ МАЯГТ

### ҮННИЙ САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон усгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
- Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
- Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</b>                         | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.  |
| <b>2. Төслийн менежерийн шийдвэр</b>                        | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.   |
| <b>3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</b> | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.  |
| <b>4. Аюулгүй байдал</b>                                    | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.<br><br>4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гол түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| <b>5. Зааварчилгаа</b>                                      | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй  |
| <b>6. Маргааныг шийдвэрлэх</b>                              | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлтэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |
| <b>B. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ</b>                    |   |
| <b>7. Ажлын хөтөлбөр</b>                                    | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.  |
| <b>8. Зөрчил, гологдол илрүүлэх</b>                         | 7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.   |
| <b>9. Зөрчил, гологдол арилгах</b>                          | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.                                    |
|   | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа <sup>1</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.  |
|   | 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.  |

<sup>1</sup> Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэл заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

## **В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ**

- 11. Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарь тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарь нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги<sup>2</sup> төлне. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

## **Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ**

- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлзуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.  
Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.  
Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ.  
Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

<sup>2</sup> Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг сүутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
- (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
- (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
- (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
- (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсоон. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

## ДОЛОО. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ<sup>3</sup>

<b>ГЕН 2.1</b>	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <i>Дорноговь аймгийн Онцгой байдлын газар</i>
<b>ГЕН 2.1</b>	Ажил нь <i>[төвч тодорхойлолт, түүний дотор төслийн хурээнд бусад гэрээтэй холбогдох байдал]</i> -аас бүрдэнэ.  Ажлын талбай нь <i>[байришил]</i> -д байрших ба зураг №...-д зааснаар тодорхойлогдсон болно.
<b>ГЕН 3.1</b>	Төслийн менежер нь <i>[томилогдсон этгээдийн нэр, хаяг]</i>
<b>ГЕН 4.1</b>	Ажил эхлэх өдөр <i>2020 оны 02 дугаар сарын 10-ны өдөр</i>  Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр <i>2020 оны 02 дугаар сарын 18-ны өдөр</i>
<b>ГЕН 7.1</b>	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш <i>ажлын 5 хоногийн</i> дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
<b>ГЕН 9.1</b>	Чанарын баталгаат хугацаа <i>2020 оны 12 дугаар сарын 25-ны өдөр</i> .
<b>ГЕН 13.1</b>	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <i>10 хувь</i> байна. <sup>4</sup>  Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <i>15 хувь</i> байна.
<b>ГЕН 17.1</b>	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад <i>“тохируулна.”</i> <b>Зөвхөн тухайн барааны зах зээлийн нэгж үнэ гэрээнд заасан үнээс 15 хувиар буурсан тохиолдолд захиалагч, нийлүүлэгч харилцан тохиролцож барааны нэгж үнийг бууруулах өөрчлөлтийг хийнэ. Барааны үнэд үүнээс өөр өөрчлөлт хийхийг хориглож энэ заалтыг гэрээний тусгай нөхцөлд тусгана.</b>

<sup>3</sup> Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна.  
Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

<sup>4</sup> Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

## НАЙМ. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

### ЗАХИАЛАГЧ

### ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

**1.** Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж сууринуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

**2.** Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

**3.** Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

**4.** Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай \_\_\_\_\_ хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай/\_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай, \_\_\_\_\_ суурь, \_\_\_\_\_ хана, \_\_\_\_\_ хүчилттай, \_\_\_\_\_ давхар \_\_\_\_\_ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж сууринуулах/-ын ажлыг \_\_\_\_\_ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, \_\_\_\_\_ туслах барилга /бусад ажил/-ын хамт \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдөр ашиглалтад оруулна.

**5.** Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1.** Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2.** Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3.** Үнийн санал
- 5.4.** Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5.** Гэрээний өрөнхий нөхцөл;
- 5.6.** Техникийн тодорхойлолт;

- 5.7.** Зураг;  
**5.8.** Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :  
**5.9.** Санхүүжилтийн хуваарь;  
**5.10.** Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

- 6.** Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.
- 7.** Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
- 8.** Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
- 9.** Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]